

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТОЛООЛОН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/33

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тус эрэлтийг хангах, өөрийн бүтээгдэхүүнийг зах зээлд үе шаттайгаар нэвтрүүлэхэд эх үүсвэрийн хэрэгцээ байгааг харгалзан “Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-аас энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. “Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. “Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-тай байгуулсан Зээлийн гэрээний гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/34

Улаанбаатар хот

Хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.11 дэх заалт Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн стратегийн түнш байгууллагатай хамтран ажиллаж буй хамтын ажиллагааг дэмжих, өргөжүүлэх зорилгоор энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасны дагуу “ОЧУН Капитал хувийн ХОС”-д оруулсан хөрөнгө оруулалтыг цааш үргэлжүүлэх, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/35

Улаанбаатар хот

Хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дэх заалт Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон Компанийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд “Ажлын төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөр”-ийг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр батлагдсан “Ажлын төлөвлөгөө”, Хавсралт №2-оор батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөр”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
3. “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөр” шинэчлэн батлагдсантай холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.

